Элэгний хатуурлын үе дэх сувилахуйн үнэлгээний аргуудыг харьцуулан судалсан байдал

Б.Хангай, Н.Мөнхзаяа, Г.Мөнхтуул, Н.Очирмаа, Б.Гэгээбадрах

Хоол Боловсруулах Эрхтэн судлалын Тасаг, УХТЭ

Түлхүүр үг:

Сувилахуйн хуудас
Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ
Мэргэшсэн сувилахуй
Үнэлгээний арга

Товч утга: Монгол улсад элэгний өвчний шалтгаант нас баралт нь хоол боловсруулах эрхтэн тогтолцоо (ХБЭТ)-ны эмгэгүүдийн дунд эхний байранд жагсаж байна. Эрүүл Мэндийн Сайдын 611 тоот тушаалын СМ-1-11 хавсралтын "Эмчлүүлэгчийн биеийн байдлыг үнэлэх хуудас"-ны дагуу эмчлүүлэгчийн биеийн байдлыг үнэлэх нь элэгний архаг өвчин, элэгний хатуурал гэх мэт нарийн төвөгтэй өвчнүүдийн үед хангалттай мэдээлэл цуглуулж, өвчтөнийг бүрэн үнэлж, сувилахуйн тусламж үзүүлэх нь учир дутагдалтай байна. Уг судалгааг УХТЭ-ийн Хоол боловсруулах эрхтэн судлалын тасагт дескриптив судалгааны загвар ашиглан хийв. Эрүүл Мэндийн Сайдын 611 тоот тушаалын СМ-1-11 хавсралтын "Эмчлүүлэгчийн биеийн байдал үнэлэх хуудас" ба өөрсдийн боловсруулсан "Элэгний хатууралтай эмчлүүлэгчийн биеийн байдлыг үнэлэх сувилгааны хуудас"-ыг харьцуулан дутагдалтай болон давуу талыг тодорхойлов. Элэгний хатуурал, түүний хүндрэлээр хэвтэн эмчлүүлэгчийг тасгийн чанарын багаас бэлтгэсэн "Элэгний хатууралтай эмчлүүлэгчийн биеийн байдлыг үнэлэх сувилахуйн хуудас"-аар үнэлж, судлахад элэгний хатуурлын үеийн сонгомол шинжүүдийг нэг дороос харах, бөглөгдсөн хуудаснаас элэгний хатууралтай эмчлүүлэгчийн эмнэлзүйн динамик өөрчлөлтийг шууд ажиглах зэрэг олон давуу талтай байлаа. Сувилахуйн үнэлгээний хуудас нь эмгэг тус бүрээр ялгаатай, тухайн эмгэгийн хүндрэлүүд дэлгэрэнгүй тусгагдсан байвал эмчлүүлэгчийн биеийн байдлыг үнэлэхэд бодит ач холбогдолтой юм.

Үндэслэл: Жил бүр дэлхий дахинаа элэгний архаг өвчин, элэгний хатуурлаас болж 2 сая хүн нас бардаг. Европийн орнуудад элэгний хатуурлын тархалт 100,000 хүн амд 833 (447-1100) байдаг ба улс орнуудад тархалт өөр байдаг.[1] МУ-д 2018 оны байдлаар 1187 хүн ХБЭТ-ны эмгэгийн улмаас нас барсан байна. Элэгний архаг өвчний нарийн төвөгтэй байдал, шаардлагатай эмчилгээний горим нь эмчлүүлэгчид аюулгүй асаргаа сувилгааны тусламж үзүүлэх, эмчлүүлэгчийн амьдралын чанарыг дэмжих асуудал байдаг. Энэ нь сувилагчийн хувьд сувилгааны ур чадвар ихээхэн шаардсан сорилт болдог.[2] Сувилагчид эмчлүүлэгчийн биеийн байдал, эрүүл мэндийг үнэлэх нь тасралтгүй байнгын ажиллагааны үр дүн.[3]

УХТЭ-ийн хүрээнд Эрүүл Мэндийн Сайдын 611 тоот тушаалын СМ-1-11 хавсралтын "Эмчлүүлэгчийн биеийн байдлыг үнэлэх хуудас" буюу стандарт хуудасын дагуу эмчлүүлэгчийн биеийн байдлыг үнэлдэг. Тус хавсралтад олон эрхтэн тогтолцоог үнэлэхэд зориулагдсан ба бүх өвчнүүдэд адил хэрэглэгддэг нь хоол боловсруулах эрхтэн тогтолцооны эмгэгтэй хүмүүсийг нарийн үнэлэх, сувилгааны төлөвлөгөө гаргахад хангалттай хэмжээний мэдээлэл авах боломжгүй, ерөнхий мэдээлэл бүртгэхэд зориулсан байдаг. Тиймээс элэгний архаг эмгэгийн үеийн шаардлагатай сувилахуйн тусламж үйлчилгээг чанартай, аюулгүй, хүртээмжтэй үзүүлэхийн тулд элэгний архаг эмгэгийн үед илэрдэг шинж тэмдгүүдийг тусгайлан бүртгэж, үнэлэх шаардлага тулгарч байна. Зөвхөн Хоол Боловсруулах Эрхтэн Судлалын Тасаг (ХБЭСТ) төдийгүй бусад нарийн мэргэжлийн тасгуудад тохиолддог нарийн төвөгтэй өвчнүүдийн үед тухайн өвчний явцыг харуулах өвөрмөц шинжүүдийг мэдээлэх сувилахуйн үнэлгээний хуудас хэрэгтэй юм.


Зорилго: Стандарт хуудас болон ХБЭСТ-ийн тасгийн чанарын багаас боловсруулсан "Элэгний хатууралтай эмчлүүлэгчийн биеийн байдлыг үнэлэх сувилгааны хуудас"-ыг харьцуулан судлах юм.

Зорилт:

1. Элэгний хатууралтай эмчлүүлэгчдэд зориулсан сувилахуйн хяналтын хуудсыг боловсруулж, эмнэлгийн тусламж үйлчилгээнд нэвтрүүлэх
2. Стандарт хуудас болон "Элэгний хатууралтай эмчлүүлэгчийн биеийн байдлыг үнэлэх сувилгааны хуудас"-ыг харьцуулан үнэлэх

Хэрэглэгдэхүүн ба арга аргачлал: УХТЭ-ийн Хоол боловсруулах эрхтэн судлалын тасагт судалгааг явуулсан ба дескриптив судалгааны загвар ашиглав. Стандарт хуудас ба өөрсдийн боловсруулсан "Элэгний хатууралтай эмчлүүлэгчийн биеийн байдлыг үнэлэх сувилгааны хуудас"-ыг харьцуулан дутагдалтай болон давуу талыг тодорхойлов.

Үр дүн: 2019 оны 1-р сараас 2020 оны 3-р сарын хооронд УХТЭ-ийн Хоол боловсруулах эрхтэн судлалын тасагт нийт 1632 хүн хэвтэн эмчлүүлсний 379 хүн (24%) нь элэгний хатуурал оношоор хэвтэн эмчлүүлсэн байна. Элэгний хатуурал оношоор хэвтэн эмчлүүлсэн хүмүүсийн хүндрэлийн төрлийг Зураг1-т харуулав.



Зураг 1. Элэгний хатуурал оношоор хэвтэн эмчлүүлсэн хүмүүсийн хүндрэлийн төрөл

2020 оны 1-р сараас эхлэн элэгний хатуурал, түүний хүндрэлээр хэвтэн эмчлүүлэгчдээс цус алдаж ирсэн 24, хэвлийн хөндийд шингэн хурсан 54 эмчлүүлэгчийг тасгийн чанарын багаас бэлтгэсэн "Элэгний хатууралтай эмчлүүлэгчийн биеийн байдлыг үнэлэх сувилахуйн хуудас" ба стандарт хуудсаар үнэлж, харьцуулан судлахад хэд хэдэн давуу болон сул талууд ажиглагдсаныг Хүснэгт 1-т харуулав.

Хүснэгт 1. Стандарт хуудас болон Элэгний хатууралтай эмчлүүлэгчийг үнэлэх сувилгааны хуудасны харьцуулсан байдал

	Стандарт хуудас	Элэгний хатууралтай эмчлүүлэгчийн биеийн байдлыг үнэлэх сувилахуйн хуудас
Давуу тал:	● Ихэнх эрхтэн тогтолцооны үйл ажиллагааг үнэлэх үзүүлэлтүүдийг оруулсан. ● Эмчлүүлэгчийн биеийн байдлыг ерөнхийд нь цогцоор үнэлэх боломжтой.	● Элэгний хатуурлын үед өвөрмөцөөр илэрдэг шинж тэмдгүүдийг оруулсан ● Элэгний хатуурлын үеийн сонгомол шинжүүдийг нэг дороос харах ● Бөглөгдсөн хуудаснаас элэгний хатууралтай эмчлүүлэгчийн эмнэлзүйн динамик өөрчлөлтийг шууд ажиглах
Сул тал:	● Олон үзүүлэлттэй тул шаардлагатай өвөрмөц мэдээллийг ялган харахад бэрхшээлтэй ● Хоол боловсруулах эрхтэн тогтолцооны эмгэгийн үед илрэх зарим өөрчлөлт ба өвөрмөц шинжүүд тусагдаагүй.	● Бүх эрхтэн тогтолцооны ерөнхий үйл ажиллагааг багтаагаагүй тул хавсарсан эмгэгтэй тохиолдолд үнэлгээний гадуур үлдэх эрсдэлтэй

Хэлцэмж: Сувилахуйн хуудас нь эмгэг тус бүрээр ялгаатай, тухайн эмгэгийн хүндрэлүүд дэлгэрэнгүй тусагдсан байвал эмчлүүлэгчийн биеийн байдлыг үнэлэхэд бодит ач холбогдолтой. Сувилагч нар нарийн асуумжийн дагуу мэдээлэл цуглуулж эмнэлгийн тусламж үйлчилгээнд хэрэглэснээр асаргаа сувилгааны чанар болон аюулгүй байдал сайжирна.[4]

Дүгнэлт: Сувилахуйн нарийн мэргэжлийн хуудсыг эмгэг тус бүрээр боловсруулан хэрэглэх нь үндсэн өвчний талаарх мэдээллийг цуглуулах боловч бусад хавсарсан эмгэгийг илтгэх үзүүлэлтүүдийг орхигдуулах магадлалтай тул стандарт "Эмчлүүлэгчийн биеийн байдал үнэлэх хуудас"-ыг орхигдуулахгүй нэмэлтээр хөтлөх хэрэгтэй.

Ном зүй:

1. *Moon AM, Singal AG, Tapper EB. Contemporary Epidemiology of Chronic Liver Disease and Cirrhosis. Clinical gastroenterology and hepatology : the official clinical practice journal of the American Gastroenterological Association. 2019.*
2. *Werner KT, Perez ST. Role of nurse practitioners in the management of cirrhotic patients. The Journal for Nurse Practitioners. 2012;8(10):816-21.*
3. *Christensen PJ, Kenney JW. Nursing process application of conceptual models. 1995.*
4. *Guilherme C, Carvalho Ed, Landeros López M. Relevance of data collection instruments for quality of care. Enfermería Global. 2012;27:328-36.*

A comparative study of nursing evaluation methods in cirrhosis

B.Khangai, N.Monkhzaya, G.Monkhtuul, N.Ochirmaa, B.Gegeebadrakh

Department of gastroenterology, Second State Central Hospital

Abstract: Chronic liver disease and cirrhosis are the most complicated and high mortality rate disease in the world. Complicity of chronic liver disease and special treatment regimen are a challenge that requires good nursing skills to maintain safe healthcare and support patients quality of life. Assessing patients' health status by using a standard assessment list approved by the Minister of Health's Order could not gather sufficient information about complicated patients. Therefore, to develop the "Nursing assessment list for patients with cirrhosis" and to compare with the currently using standard assessment list was the aim of this research. We conducted a descriptive study. Assessing patients' health status by using the standard list was difficult to extract special features because of its attribute that gathering too many fields and some gastroenterological signs remained. Using a nursing assessment list for patients with cirrhosis gave us the opportunity to see classic signs of cirrhosis and dynamic change of patients' health status directly. For strengthening nursing care we need to develop and use more nursing assessment lists for each common disease that requires special healthcare.

Keywords: Nursing checklist, health care, nursing specialties, assessment tools